



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2025 оны 08 сарын 17 өдөр

Дугаар 03/21

Арвайхээр сум

**“Салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах
журмыг шинэчлэн батлах тухай”**

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг, Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажиллах нийтлэг журам”-ыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Өвөрхангай аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, түүний ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймаг, сумдын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах-салбар зөвлөлд тус тус даалгасугай.

3.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн “Салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн батлах тухай” 09/08 дугаар тогтоол, 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн “Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” 16/06 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



НАРАНГАРАВ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 4 дугаар сарын 17-ны өдрийн
10/100 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ
ЗОХИЦУУЛАХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Зөвлөлийн дарга: Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга

Гишүүн: Аймгийн Засаг даргын орлогч;

Аймгийн Прокурорын газрын ерөнхий прокурор;

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга;

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн
дарга;

Аймгийн Байгаль орчны газрын дарга;

Аймгийн Боловсролын газрын дарга;

Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга;

Аймгийн Цагдаагийн газрын дарга;

Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга;

Бүсийн шүүх шинжилгээний төвийн дарга;

Аймгийн Тагнуулын хэлтсийн дарга;

Дотоодын цэргийн 833 дугаар тусгай салбарын захирагч;

Аймгийн Төрийн үйлчилгээ-мэдээллийн төвийн дарга;

Нарийн бичгийн дарга: Аймгийн ИТХ-ын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил
хариуцсан мэргэжилтэн

--- оОо ---

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн
02/02 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Өвөрхангай аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл /цаашид "Салбар зөвлөл" гэх/-ийн үйл ажиллагааг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, энэхүү журам болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

1.2. Харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах, хяналт тавих, үр дүнг тооцох, нийгмийн дэг журмыг бэхжүүлэх, хуулиар хүлээсэн үүрэг бүхий төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагааг уялдуулах, иргэний ухамсар, соёлыг төлөвшүүлэхэд энэхүү журмын зорилго оршино.

Хоёр. Салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, зохион байгуулалт

2.1. Салбар зөвлөл нь дарга, гишүүд, орон тооны нарийн бичгийн даргаас бүрдэнэ.

2.2. Салбар зөвлөл нь 9-17 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд салбар зөвлөлийн дэргэд тухайлсан чиглэлээр дэд зөвлөл ажиллуулж болно.

2.3. Салбар зөвлөл нь орон тооны ажлын албатай байж болох бөгөөд бүтэц бүрэлдэхүүнийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

2.4. Салбар зөвлөл нь эрхлэх асуудлын чиглэлээр ажлын хэсэг, судалгааны баг байгуулж болно.

2.5. Салбар зөвлөл үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

2.6. Салбар зөвлөлийн хуралдааны шийдвэр нь тогтоол, зөвлөмж, мэдэгдэл хэлбэртэй байна.

2.7. Салбар зөвлөлийн ээлжит хуралдааныг улиралд нэгээс доошгүй удаа хийх бөгөөд нийт гишүүдийн олонх оролцсоноор хуралдааныг хүчинтэйд тооцно.

2.8. Салбар зөвлөлийн ээлжит бус хуралдааныг даргын санаачилгаар, эсхүл салбар зөвлөлийн гишүүдийн олонхын саналаар хуралдуулж болно.

2.9. Салбар зөвлөлийн хуралдааныг цахим хэлбэрээр зохион байгуулж болно.

2.10. Салбар зөвлөлийн даргын эзгүйд ээлжит болон ээлжит бус хуралдааныг даргын эрх олгосноор салбар зөвлөлийн аль нэг гишүүн удирдана.

2.11. Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг хуралдаанд оролцсон нийт гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ. Гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд асуудлыг хуралдаан даргалагчийн саналаар шийдвэрлэнэ.

2.12. Салбар зөвлөлийн хуралдааныг тэмдэглэл хөтөлж баталгаажуулах бөгөөд түүнд салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурна.

2.13. Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга, гишүүд нь салбар зөвлөлийн даргын гарын үсэг, тэмдэг бүхий үнэмлэхтэй байж болно.

2.14. Салбар зөвлөл нь Засгийн газраас тогтоосон журмын дагуу үйлдсэн албан ёсны хэвлэмэл хуудас хэрэглэнэ. Тус хэвлэмэл хуудсанд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэмдгийг хэрэглэнэ.

Гурав. Салбар зөвлөлийн бүрэн эрх

3.1. Салбар зөвлөл нь Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэгт заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Дөрөв. Салбар зөвлөлийн дарга, гишүүний бүрэн эрх

4.1. Салбар зөвлөлийн дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

- 4.1.1. Салбар зөвлөлийн тухайн жилийн ажлын төлөвлөгөөг салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих;
- 4.1.2. Салбар зөвлөлийн ээлжит болон ээлжит бус хуралдаанаар хэлэлцэх асуудлыг тогтоож, хуралдааныг товлох, даргалах;
- 4.1.3. Салбар зөвлөлийн гишүүдэд үүрэг, даалгавар өгч, биелэлтэд хяналт тавих;
- 4.1.4. Салбар зөвлөлийг дотоод, гадаад харилцаанд төлөөлөх;

4.2. Салбар зөвлөлийн гишүүн дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

- 4.2.1. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд санал өгөх, төлөвлөгөө, тайлантай танилцах, салбар зөвлөлөөс хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар мэдээлэл авах;
- 4.2.2. Салбар зөвлөлийн хуралдаанаас гарсан шийдвэрийн явц, үр дүнг хэрэгжүүлэх, эрчимжүүлэх хүрээнд хариуцсан салбар, чиглэлийн дагуу хяналт тавих;
- 4.2.3. Салбар зөвлөлийн даргын өгсөн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлэх, тайлагнах, хариуцсан салбар чиглэлийн дагуу салбар зөвлөлд холбогдох мэдээ, тайлан, статистик тоо баримтыг гаргаж өгөх;
- 4.2.4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг өөрийн байгууллагын холбогдох албан хаагчаар хариуцуулан гүйцэтгүүлэх;

4.3. Салбар зөвлөлийн гишүүн хуралдаанд өөрийн биеэр оролцоно.

4.4. Салбар зөвлөлийн гишүүн хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралдаанд оролцох боломжгүй тохиолдолд хуралдаанаар хэлэлцэх асуудлын талаарх саналаа урьдчилан бичгээр хүргүүлж болно.

Тав. Салбар зөвлөлийн дэргэдэх дэд зөвлөл

5.1. Аймгийн хэмжээнд тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг дагнан зохицуулах үүрэг бүхий зөвлөлийг /цаашид "Дэд зөвлөл" гэх/ салбар зөвлөлийн дэргэд ажиллуулна.

5.2. Дэд зөвлөлийн зохион байгуулалт, бүрэлдэхүүнийг салбар зөвлөл тогтооно.

5.3. Салбар зөвлөлийн гишүүдээс дэд зөвлөлийн даргыг сонгоно.

5.4. Салбар зөвлөлийн дэргэдэх дэд зөвлөл нь Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлд зааснаар тухайн жилд хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.

5.5. Дэд зөвлөлийн дарга тухайн жил хэрэгжүүлэх зорилт арга хэмжээний төлөвлөгөөг салбар зөвлөлийн төлөвлөгөөнд нийцүүлэн 1 дүгээр улиралд багтаан салбар зөвлөлийн даргаар баталуулна.

5.6. Хуралдаанаас санал, зөвлөмж гарч болох бөгөөд салбар зөвлөлийн нарийн бичгийн даргад танилцуулж, дэд зөвлөлийн дарга гарын үсэг зурна.

5.7. Дэд зөвлөлийн үндсэн үйл ажиллагаа нь хуралдаан байх бөгөөд жилд 2-оос доошгүй удаа хуралдаж, хуралдааны тэмдэглэл хөтөлж баталгаажуулна.

5.8. Дэд зөвлөл нь тухайн оны үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг хагас жилээр 6 дугаар сарын 20-ны дотор, бүтэн жилээр 12 дугаар сарын 20-ны дотор аймгийн салбар зөвлөлд ирүүлнэ.

Зургаа. Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын чиг үүрэг

6.1. Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

- 6.1.1. Салбар зөвлөлийн өдөр тутмын ажлыг хариуцан, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;
- 6.1.2. Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг боловсруулж, салбар зөвлөлийн даргаар батлуулах;
- 6.1.3. Салбар зөвлөлийн хуралдааныг зохион байгуулах бэлтгэл ажил хангах;
- 6.1.4. Салбар зөвлөлийн хуралдаанаас гарсан шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах ажилд хяналт тавьж, зохион байгуулах;
- 6.1.5. Хариуцсан нутаг дэвсгэрийн гэмт хэргийн нөхцөл байдал, түүнээс урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг холбогдох байгууллагуудаас гаргуулан авах;
- 6.1.6. Салбар зөвлөлийн тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, явцын талаар салбар зөвлөлд танилцуулах;
- 6.1.7. Салбар зөвлөлийн үйл ажиллагааг олон нийтэд мэдээлэх, сурталчлах;
- 6.1.8. Дэд зөвлөл болон сумдын салбар зөвлөлийн үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;
- 6.1.9. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн хуралдаанд жил бүр танилцуулах;
- 6.1.10. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр судалгаа мэдээллийн сан үүсгэх бөгөөд төрийн болон албаны нууцын тухай хуульд зааснаас бусад мэдээ, тоо баримт, судалгааг холбогдох байгууллагаас гаргуулах;

Долоо. Сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл

7.1. Сумын салбар зөвлөлийн ажиллах журмыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан журамд нийцүүлэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

7.2. Сумын салбар зөвлөл нь Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16, 17 дугаар зүйлд заасан өөрийн чиг үүрэгт хамаарах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

7.3. Сумын салбар зөвлөл нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 192 дугаар тогтоолоор батлагдсан "Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын нэгдсэн тайлан, мэдээ гаргах, түүнд дүн шинжилгээ

хийх болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг үнэлэх журам"-ыг мөрдөнө.

7.4.Сумын салбар зөвлөлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын тайлан, мэдээг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга хариуцан, салбар зөвлөлийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

7.5.Сумын салбар зөвлөлийн тайлан мэдээг хагас жилээр 6 дугаар сарын 20-ны дотор, бүтэн жилээр 12 дугаар сарын 20-ны дотор аймгийн салбар зөвлөлд ирүүлнэ.

--- оОо ---